



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ ШҮҮХИЙН ТОГТООЛ

2021 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Ардчилсан нам /АН/-аас ирүүлсэн
хүсэлтийг хэлэлцэх тухай

Монгол Улсын Дээд шүүхийн шүүх хуралдааныг шүүгч Г.Алтанчимэг даргалж, шүүгч Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийж, намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх, цахим мэдээллийн санд бүртгэлтэй Ардчилсан нам /АН/-ын дарга С.Эрдэнийн бүртгэлийг сэргээх, намын дараагийн дарга сонгогдох хүртэл намын даргын бүртгэлд Ц.Тувааныг бүртгүүлэх талаар Улсын Дээд шүүхэд гаргасан Ардчилсан нам /АН/-ын хүсэлтийг хянан хэлэлцэв.

Шүүх хуралдаанд: Ардчилсан нам /АН/-аас С.Эрдэнэ, О.Баасанхүү, Н.Ариунболд, Г.Батбаяр, П.Нүрээд, Б.Мягмардаш, Д.Нямхүү, О.Алтангэрэл, Л.Батмөнх, Ш.Түвдэндорж, хуралдааны тэмдэглэл хөтлөхөөр шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Х.Билгүүн нар оролцов.

ТОДОРХОЙЛОХ нь:

1. Ардчилсан нам /АН/-ын Хэрэг эрхлэх газрын дарга А.Цэрэнбат 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Улсын Дээд шүүхэд ирүүлсэн хүсэлтдээ: “2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн Улсын Дээд шүүхийн хуралдаанаар Улс төрийн намын тухай хуулийн 13.9, 21.1 дэх хэсэгт зааснаар Ардчилсан нам /АН/-ын хяналтын байгууллага намын даргын асуудлаа эцэслэн шийдвэрлэсний дараа цахим бүртгэлд бүртгүүлэх асуудлыг нээлттэй үлдээсэн. ...Уг тогтоолын дагуу Үндэсний бодлогын хороо болон Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-д 2021 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр ээлжит бус цахим хурлаа хийж, Ардчилсан нам /АН/-ын шинэ дарга сонгогдтол С.Эрдэнэ бүрэн эрхтэй байхыг 05 дугаар тогтоолоор батламжилсан. Иймд Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.9-д зааснаар Ардчилсан нам /АН/ удирдлагын талаарх асуудлаа эцэслэн шийдвэрлэсэн тул цахим мэдээллийн санд Ардчилсан нам /АН/-ын даргаар С.Эрдэнийг дахин байршуулж өгнө үү.” гэж,

Хүсэлтэд: 2021 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн Ардчилсан нам /АН/-ын Үндэсний бодлогын хороо /ҮБХ/-ны ээлжит бус цахим хурлын 05 дугаар тогтоолыг хавсарган ирүүлжээ.

2. Ардчилсан нам /АН/-ын Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-ны дарга Х.Ганболд 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдөр Улсын Дээд шүүхэд ирүүлсэн хүсэлтдээ: “...Ардчилсан нам /АН/-ын эрх бүхий, төлөөллийн төв байгууллагууд Улсын Дээд шүүхийн 04 тоот тогтоолд дурдсаны дагуу Үндэсний бодлогын хороо /ҮБХ/ 2021 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 17 дугаар хуралдаан, Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/ 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдөр тус тус хуралдаж 05 дугаар тогтоолоор Ардчилсан нам /АН/-ын шинэ дарга сонгогдтол С.Эрдэнэ бүрэн эрхтэй байхыг батламжилсан. Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.9-д зааснаар Ардчилсан нам /АН/-ын эрх бүхий байгууллага, намын дарга, түүнийг төлөөлөх этгээдийн талаар дотооддоо шийдвэрлэсэн болно.

2017 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн Ардчилсан нам /АН/-ын 7 дугаар их хурлын 03 дугаар тогтоолоор Ардчилсан нам /АН/-ын даргаар С.Эрдэнэ сонгогдсоныг Улсын Дээд шүүхийн 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэсэн. Гэтэл Ардчилсан нам /АН/-ын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудлаар Улсын Дээд шүүхийн шийдвэр гаргаагүй байхад шүүхийн цахим

бүртгэлд өөрчлөлт орж Ц.Тувааныг Ардчилсан нам /АН/-ын даргын үүрэг гүйцэтгэгчээр тэмдэглэсэн нь Улсын Дээд шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор хүчингүй болсон. Иймд Ардчилсан нам /АН/-ын дарга шинээр сонгогдож, хуулийн этгээдийн улсын бүртгэлд шинээр бүртгүүлэх хүртэл Улсын Дээд шүүхийн цахим мэдээллийн санд Ардчилсан нам /АН/-ын даргаар С.Эрдэнэ гэж тэмдэглэгдсэн байсныг сэргээж өгнө үү” гэж,

Хүсэлтэд: Ардчилсан нам /АН/-ын Улсын бүртгэлийн гэрчилгээ, тамга, тэмдгийн хяналтын дугаарын Улсын бүртгэлийн хуудас, Улсын бүртгэлийн Ерөнхий газрын 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 8/190 албан тоот, Улсын Дээд шүүхийн 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоол, Ардчилсан нам /АН/-ын Үндэсний бодлогын хороо /ҮБХ/-ны ээлжит бус цахим хурлын 01 дүгээр сарын 10-ны өдрийн 10, 11 дүгээр тогтоол, Ардчилсан нам /АН/-ын Үндэсний бодлогын хороо /ҮБХ/-ны ээлжит бус цахим хурлын 2021 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 05 дугаар тогтоол, Ардчилсан нам /АН/-ын Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-ны 2020 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 16 дугаар тайлбар, Ардчилсан нам /АН/-ын Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-ны 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 02, 03, 04 дүгээр тогтоолыг тус тус хавсарган ирүүлжээ.

3. Ардчилсан нам /АН/-ын Хэрэг эрхлэх газрын дарга А.Цэрэнбат 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Улсын Дээд шүүхэд ирүүлсэн хүсэлтдээ: “...Ардчилсан нам /АН/-ын эрх бүхий, төлөөллийн төв байгууллагууд Улсын Дээд шүүхийн 04 тоот тогтоолд дурдсаны дагуу Үндэсний бодлогын хороо /ҮБХ/ 2021 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 17 дугаар хуралдаан, Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/ 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдөр тус тус хуралдаж 05 дугаар тогтоолоор Ардчилсан нам /АН/-ын шинэ дарга сонгогдтол С.Эрдэнэ бүрэн эрхтэй байхыг батламжилсан. Иймд Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.9-д зааснаар Ардчилсан нам /АН/ удирдлагын талаарх асуудлаа эцэслэн шийдвэрлэсэн тул цахим мэдээллийн санд Ардчилсан нам /АН/-ын даргаар С.Эрдэнийг дахин байршуулж, тэмдэглэлийг сэргээж өгнө үү” гэж,

Хүсэлтэд: Ардчилсан нам /АН/-ын Улсын бүртгэлийн гэрчилгээ, тамга, тэмдгийн хяналтын дугаарын Улсын бүртгэлийн хуудас, Улсын бүртгэлийн Ерөнхий газрын 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 8/190 албан тоот, Улсын Дээд шүүхийн 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоол, Ардчилсан нам /АН/-ын Үндэсний бодлогын хороо /ҮБХ/-ны ээлжит бус цахим хурлын 01 дүгээр сарын 10-ны өдрийн 10, 11 дүгээр тогтоол, Ардчилсан нам /АН/-ын Үндэсний бодлогын хороо /ҮБХ/-ны ээлжит бус цахим хурлын 2021 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 05 дугаар тогтоол, Ардчилсан нам /АН/-ын Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-ны 2020 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 16 дугаар тайлбар, Ардчилсан нам /АН/-ын Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-ны 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 02, 03, 04 дүгээр тогтоолыг тус тус хавсарган ирүүлжээ.

4. Ардчилсан нам /АН/-ын Хэрэг эрхлэх газрын дарга А.Цэрэнбат 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдөр Улсын Дээд шүүхэд ирүүлсэн хүсэлтдээ: “2020 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Ардчилсан нам /АН/-ын 1117237845 дугаар бүхий тамгыг Улсын бүртгэлийн ерөнхий газраас хүчингүйд тооцож 9020120477 хяналтын шинэ дугаар олгосон. Тиймээс тамганы хяналтын дугаар өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Ардчилсан нам /АН/-ын тэмдгүүд хүчингүй болсныг нотолж байна. Мөн Улсын Дээд шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор Ц.Тувааныг Ардчилсан нам /АН/-ыг төлөөлөх эрхгүй болохыг нотлон шийдвэрлэж цахим бүртгэлээс хассан. Гэтэл Улсын Дээд шүүх тухайн хүчингүйд тооцсон тамга, тэмдгийн дардас бүхий хүсэлт, гомдлуудыг удаа дараа ханган шийдвэрлэж байгаа нь хууль бус байгууллага тамга тэмдэг ашиглах, хэрэглэх журам /ЗТХ-ийн 10.20.1/ зөрчиж байгааг харуулж байна. Иймд хүчингүйд тооцсон тамга, тэмдгийн дардас бүхий Ардчилсан нам /АН/-ын хэрэг эрхлэх газрын нэрийг барьсан П.Нүрзэд гэгч этгээдийн хүсэлт, гомдлыг хүлээн авахгүй байхыг хүсье” гэжээ.

5. Ардчилсан нам /АН/-ын Хэрэг эрхлэх газрын дарга А.Цэрэнбат 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Улсын Дээд шүүхэд ирүүлсэн хүсэлтдээ: “Улсын Дээд шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр хуралдаад Ардчилсан нам /АН/-ын 10 дугаар Их хурлаар батлагдсан гэх тус намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бүртгэхээс

татгалзсан. ...Үүнээс хойш Ардчилсан нам /АН/-ын Их хурал хуралдаагүй байгаа бөгөөд 2021 оны 05 дугаар сарын 02-ны өдөр намын Их хурлыг товлон зарласан байгаа болно.

...Улсын Дээд шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор цахим бүртгэлээс Ц.Тувааныг Ардчилсан нам /АН/-ын даргын үүрэг гүйцэтгэгчээр бүртгэснийг хассан байдаг. Үүнээс хойш Ц.Тувааныг Ардчилсан нам /АН/-ын дарга эсхүл үүрэг гүйцэтгэгчээр бүртгэсэн Дээд шүүхийн шийдвэр гаргаагүй, түүнчлэн тус намын эрх бүхий этгээдийн шийдвэрээр түүнийг намын дарга, түүнтэй адилтгах албан тушаалд сонгоогүй байгаа. Тиймээс Ц.Туваан нь Ардчилсан нам /АН/-ыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхгүй учир намын үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт оруулахаар Дээд шүүхэд хүсэлт гаргах эрх зүйн чадамжгүй, энэ нь намын дотоод хүрээнд маргаантай байгаагаас гадна улсын бүртгэлийн маргаантай байгаа, намыг төлөөлөх итгэмжлэл байхгүй тул түүний гаргасан хүсэлтийг буцаан татан авах хүсэлт гаргаж байна.

...Улсын Дээд шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 04 дүгээр тогтоолд дурдсан зөрчлүүд арилаагүй бөгөөд тус намын Их хурлыг хуралдаан болохоос 14 хоногийн өмнө зарлаж, дахин хуралдуулснаар зөрчил арилах боломжтой юм.

...Улсын Дээд шүүхэд бүртгэгдсэн тус намын дүрмийн 5 дугаар бүлгийн 5.22.5.1-д зааснаар намын Их хурлын төлөөлөгч сонгох сонгуулийг Дотоод сонгуулийн хороо зохион байгуулдаг. Ардчилсан нам /АН/-ын 10 дугаар Их хурлын төлөөлөгчийг сонгох сонгуулийг Дотоод сонгуулийн хороо зохион байгуулаагүй гэдгийг Дээд шүүхэд урьд мэдэгдсэн ба зарим аймаг, дүүрэг дэх Дотоод сонгуулийн хорооны тамга, албан тоот хуурамчаар нөхөн үйлдэж Дээд шүүхэд хүргүүлсэн гэсэн мэдээлэл аваад байна. Өөрөөр хэлбэл тооллогын комиссын тогтоол, хуралдааны тэмдэглэл зэргийг нөхөж зассан, холбогдох хүмүүс гарын үсэг зураагүй байна.

Ардчилсан нам /АН/-ын Их Хурал дахиж хуралдаагүй байхад Дээд шүүхэд хүргүүлсэн дүрмийн өөрчлөлтийг дахиж засаж, өөрчилж дахин Дээд шүүхэд хүргүүлсэн байгаа нь тус намын Их хуралд хадгалагддаг дүрэм нэмэлт, өөрчлөлт оруулах онцгой бүрэн эрх /Үндсэн дүрмийн 5.12.4.1/-д халдсан, Улс төрийн намын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, дүрэм зөрчсөн үйлдэл гэж үзэж байна.

Иймд Улсын Дээд шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 04 дүгээр тогтоолд дурдсан зөрчил арилаагүй, уг тогтоолд дурдсан зөрчлийг Улс төрийн намын тухай хууль, Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль, дүрэмд нийцүүлэн намын Их хурлыг зарлан хуралдуулж байж арилгах боломжтой гэж үзэж байгаа учраас Ардчилсан нам /АН/-ын дүрэмд оруулсан 5 нэмэлт, өөрчлөлтийг буцаана уу” гэж,

Хүсэлтэд: Ардчилсан нам /АН/-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Их хурлын тэмдэглэл, Ардчилсан нам /АН/-ын Үндэсний бодлогын хороо /ҮБХ/-ны ээлжит бус цахим хурлын 2021 оны 01 дүгээр сарын 09 дүгээр тогтоол, Ардчилсан нам /АН/-ын Үндэсний бодлогын хороо /ҮБХ/-ны ээлжит бус цахим хурлын 2021 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 09 дүгээр тогтоолыг тус тус хавсарган ирүүлжээ.

6. Ардчилсан нам /АН/-ын дарга С.Эрдэнэ 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Улсын Дээд шүүхэд ирүүлсэн хүсэлтдээ: “УИХ-ын гишүүн Ц.Туваан, иргэн П.Нүрзэд нараас тус шүүхэд намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хүсэлт ирүүлснийг хянан шийдвэрлэх гэж байгааг хүлээн зөвшөөрөхгүй байна.

Учир нь намыг төлөөлөх эрх бүхий этгээд шүүхэд хүсэлт ирүүлээгүй, намын дүрэмд өөрчлөлт оруулахын тулд намын Их хуралдах ёстой байтал одоогоор намын Их хурал хийгдээгүй. Ц.Туваан намын Их хурлыг зарлан хуралдуулсан нь дүрмийн 5.12.4.1, 5.12.2-д заасныг зөрчсөн. Ц.Туваан намын даргыг төлөөлөх эрхтэй эсэх нь маргаантай, энэ талаар намын дотоод хүрээнд маргаантай асуудал үүссэн, эрх бүхий этгээд зарласан эсэхийг дүгнэх боломжгүй. ...намын Их хурлыг 14 хоногийн өмнө зарлана гэсэн тус намын УТЗ-өөр баталгаажуулсан заалт зөрчигдсөн, ...Их хуралд оролцох болсон, оролцсон төлөөлөгчдийн тоо зөрүүтэй, төлөөлөгчдийн талаарх мэдээлэл тодорхой бус, хуралд сонгогдсон болон томилогдсон, оролцсон төлөөлөгчид хэн болох, хурлын товыг хэрхэн мэдэгдсэн нь тогтоогдоогүй байна. ...Их хурлыг цахимаар хийсэн гэх боловч тухайн дэгийг ирүүлээгүйгээс хурал дэгийн дагуу явагдсан эсэхэд дүгнэлт хийх боломжгүй, намын дүрэмд өөрчлөлт оруулахдаа хэдэн хувьд нь өөрчлөлт оруулсан, үг үсгийн өөрчлөлтийг ялгаж заагаагүй, үндсэн дүрмийн аль хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулснаа тодорхой тусгаж ойлгомжтой байдлаар баримтыг ирүүлээгүй, мөн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг Үндэсний

бодлогын хороо /ҮБХ/-ны гишүүдээр дэмжүүлж их хурлын хуралдаанаар хэлэлцүүлэхээр болсон гэх боловч өмнө нь намын анхан болон дунд шатны байгууллагуудаар хэлэлцсэн, санал авсан эсэх нь тодорхойгүй байна.

...Түүнчлэн Ардчилсан нам /АН/-ын 2017 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 7 дугаар Их хурлын 03 дугаар тогтоолыг Улсын дээд шүүхэд хүргүүлсний дагуу шүүхээс 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоол гарч намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд буюу намын дарга нь С.Эрдэнэ болохыг албан ёсоор баталгаажуулсан, энэхүү шийдвэрийг аль ч тал үгүйсгэсэн, өөрчилсөн аливаа хурал, шийдвэрүүд гараагүй. Харин Улсын Дээд шүүхээс 2021 оны 01 дүгээр сарын 14-өдрийн 04 тоот тогтоолоор Ц.Тувааны мэдээллийг цахим бүртгэлээс хассан. Гэтэл өнөөг хүртэл Улсын Дээд шүүхийн зүгээс Ардчилсан нам /АН/-ын дарга С.Эрдэнийг цахим мэдээллийн санд сэргээн оруулахгүй байсаар байна. Тиймээс Улсын Дээд шүүхийн цахим мэдээллийн бүртгэлд намын дарга С.Эрдэнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд гэх Улсын Дээд шүүхийн 2017 оны 01 дүгээр тогтоолыг сэргээн, буцаан байршуулахыг шаардаж байна.

...Мөн Улсын Дээд шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 04 дүгээр тогтоолд дурдагдсан зөрчлүүд бүрэн арилаагүй байхад иргэн П.Нүрзэдээс маргаан бүхий тамганы дардастай хүсэлтийг дахин хүргүүлснийг хүлээн авахаас татгалзаж, хуулийн этгээдийн хүсэлтэд тавигдах шаардлага хангаагүй гэх үндэслэлээр буцаан хүргүүлнэ үү” гэжээ.

7. Ардчилсан нам /АН/-ын Хэрэг эрхлэх газрын дарга П.Нүрзэд, намын Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-ны дарга Б.Мягмардаш нар 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдөр Улсын Дээд шүүхэд ирүүлсэн хүсэлтдээ: ...Улсын Дээд шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 04 дүгээр тогтоолд заасны дагуу намын ээлжит бус 10 дугаар Их хурлаас баталсан дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг Улсын бүртгэлд бүртгүүлэхээр дахин хандаж байна.

...Тус намын Их хурал 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдөр хуралдаж, үндсэн дүрэмд зохих журмын дагуу нэмэлт, өөрчлөлт оруулан баталж, 10/03 дугаар тогтоолоороо баталгаажуулсан. ...уг өөрчлөлт, нэмэлт нь Монгол Улсын Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль болон холбогдох бусад хуульд бүрэн нийцсэн, зохих шаардлагыг хангасан бөгөөд Улсын Дээд шүүхийн 04 тоот тогтоолд дурдсанчлан хуульд харшилсан зохицуулалт туссан талаарх асуудал, шаардлага огт тусгагдаагүй, зохих хяналтыг хийж хууль, дүрэм, журамд заасан чиг үүрэг, бүрэн эрхийнхээ дагуу шийдвэрлэсэн болно.

...Иймд Ардчилсан нам /АН/-ын ээлжид бус 10 дугаар Их хурлаар батлагдсан Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг Улсын бүртгэл бүртгэж өгнө үү” гэж,

Хүсэлтэд: Ардчилсан нам /АН/-ын 10 дугаар Их хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 10/03 дугаар тогтоол, тус тогтоолоор батлагдсан намын Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлт, Ардчилсан нам /АН/-ын 10 дугаар Их хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн тэмдэглэл, тус хурлын видео бичлэг 4 ширхэг сиди, Ардчилсан нам /АН/-ын хэрэг эрхлэх газар байрлаж буй төв байрны хаягийг тодорхойлсон Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны тодорхойлолт, Ардчилсан нам /АН/-ын Улсын бүртгэлийн гэрчилгээ, Ардчилсан нам /АН/-ын үүрэг гүйцэтгэгч Ц.Тувааны 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/02 дугаар тушаал, Улсын дээд шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 04 дүгээр тогтоолд дурдсан асуудлуудын талаарх тайлбар, түүнд холбогдох 16 боть нотлох баримтуудыг тус тус хавсарган ирүүлжээ.

8. Ардчилсан нам /АН/-ын даргын үүрэг гүйцэтгэгч Ц.Туваан 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Улсын Дээд шүүхэд ирүүлсэн хүсэлтдээ: “...намын Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэхээр гаргасан хүсэлтийг 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдөр шүүхээр хэлэлцэх хуваарь гаргасан байна. Гэтэл уг хүсэлтийг С.Эрдэнийн хүсэлттэй хамтатган шийдвэрлэх нь хууль зүйн үндэслэлгүй, ойлгомжгүй байдлыг үүсгээд байна. ...намыг төлөөлөх эрхгүй этгээд болох С.Эрдэнэ нь хязгаарлагдсан тамга, тэмдэг ашиглан намын нэрийн өмнөөс харилцаж, нийгэм, намын гишүүдийг төөрөгдөлд оруулаад байгаа үйлдлүүд нь холбогдох хууль хяналтын байгууллагад гомдол гарган шалгуулж байгаа юм. Үүний зэрэгцээгээр тус Ардчилсан нам /АН/-ын 21 аймаг, 9 дүүргийн намын байгууллагын Хэрэг эрхлэх газрын хүчин төгөлдөр тамга, тэмдгийг хаяж үрэгдүүлсэн хэмээн хуурамч зарыг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлүүлэн, зохиомол байдлыг зориудаар бий

болгож буй С.Эрдэнийн үйлдлийг тухай нэгжийн намын байгууллагаас эрс эсэргүүцэж тус намын Төв хэрэг эрхлэх газарт хандан түүнд сахилгын хариуцлага тооцохыг шаардсанаар Үндсэн дүрмийн 5 дугаар бүлгийн 5.17.1, 5.21.19, 3 дугаар бүлгийн 3.9.3.2, 3.9.3.4 дэх заалтуудаар Ардчилсан нам /АН/-ын гишүүний бүртгэлээс 8 жилийн хугацаагаар 2021 оны 01 дүгээр сарын 29-өөс хассан юм.

...Дээрх тайлбар, холбогдох хууль, дүрмийн дагуу намын дотоод маргаантай бүх асуудлаа нэг мөр эцэслэн шийдвэрлэж, энэ тухай холбогдох баримтаа шүүхэд нэгэнт хүргүүлээд байхад намын гишүүний бүртгэлээс хасагдчихсан хүний асуудлыг намын дүрмийн өөрчлөлтийг бүртгэх асуудалтай хамтатган шийдвэрлэх хуваарь гаргасан нь хоёр авчалдахгүй асуудлыг нэг үйл ажиллагаагаар шийдвэрлэх гэсэн ойлгомжгүй байдал үүсгэж байна. ...түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу УИХ-д бүлэгтэй, суудалтай нам болохын хувьд хуулиар олгогдсон эрхээ эдлэх зайлшгүй шаардлага бий болоод байна.

Иймд Ардчилсан нам /АН/-ын дүрэм, мөрийн хөтөлбөр, тэдгээрт оруулсан нэмэлт өөрчлөлт нь хуульд нийцэж буй эсэх талаарх хүсэлтийг нягтлан үзэж, шийдвэрлэж өгнө үү” гэж,

Хүсэлтэд: Ардчилсан нам /АН/-ын Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-ны 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 02 дугаар тогтоол, Ардчилсан нам /АН/-ын даргын 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн тушаал, аймаг болон нийслэлийн дүүргийн Ардчилсан нам /АН/-ын хороодын шаардлагуудыг тус тус хавсарган ирүүлжээ.

9. Ардчилсан нам /АН/-ын Хэрэг эрхлэх газрын дарга П.Нүрзэд 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Улсын Дээд шүүхэд ирүүлсэн хүсэлтдээ: “Ардчилсан нам /АН/-ын дүрмийн 3 дугаар бүлгийн 3.10.1-д зааснаар УИХ-ын 2020 оны ээлжит сонгуульд Ардчилсан нам /АН/ хамгийн олон суудал аваагүй учир Ардчилсан нам /АН/-ын дарга С.Эрдэнийг огцорсонд тооцож, дэд дарга Ц.Туваан Ардчилсан нам /АН/-ын даргын үүрэг гүйцэтгэгчээр томилогдсон. Иймд Ардчилсан нам /АН/-ын даргын цахим бүртгэлд Ц.Туваан гэж оруулж өгнө үү” гэж,

Хүсэлтэд: Нийслэл дэх Захиргааны анхан шатны шүүхийн 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 128/ШЗ2021/0955 дугаар шүүгчийн захирамж, Ардчилсан нам /АН/-ын Үндэсний бодлогын хороо /ҮБХ/-ны хурлын 2020 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 16/06 дугаар тогтоол, 2020 оны 12 дугаар сарын 17-ны 19/07 дугаар тогтоол, Ардчилсан нам /АН/-ын Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-ны 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 03 дугаар тогтоолыг тус тус хавсарган ирүүлжээ.

Хүсэлт болон хавсаргасан баримт, хуралдаанд гаргасан тайлбарыг судлан хэлэлцээд,

ХЯНАВАЛ:

Нэг. Ардчилсан нам /АН/-аас гаргасан хүсэлтүүдийг нэгтгэж үзэхэд:

1. Ардчилсан нам /АН/-ын Хэрэг эрхлэх газрын дарга А.Цэрэнбатын 2021.02.01, 2020.02.02-ны өдрүүдийн, Намын Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-ны дарга Х.Ганболдын 2021.02.02-ны өдрийн, Намын дарга С.Эрдэнийн 2021.02.25-ны өдрийн хүсэлтүүд нь тус тус “...Улсын Дээд шүүхийн цахим мэдээллийн санд Ардчилсан нам /АН/-ын даргаар бүртгэгдсэн С.Эрдэнийн бүртгэлийг сэргээж, дахин байршуулж өгнө үү...” гэсэн агуулгатай,

2. Ардчилсан нам /АН/-ын Хэрэг эрхлэх газрын дарга П.Нүрзэд, Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-ны дарга Б.Мягмардаш нарын 2021.02.08-ны өдрийн, Намын даргын үүрэг гүйцэтгэгч Ц.Тувааны 2021.02.25-ны өдрийн хүсэлтүүд нь тус тус Намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх агуулгатай,

3. Ардчилсан нам /АН/-ын Хэрэг эрхлэх газрын дарга П.Нүрзэдийн 2021.02.25-ны өдрийн хүсэлт нь Улсын Дээд шүүх дэх Ардчилсан нам /АН/-ын даргын цахим бүртгэлд Ц.Тувааныг бүртгэж өгнө үү гэсэн агуулгатай байна.

Харин хэн алиныгаа эрхгүй этгээд гэж үзэн гаргасан хүсэлтийг хэлэлцэхээс татгалзах, мөн намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгэлийг тусад нь шийдвэрлүүлэх хүсэлт гаргасныг шүүх хангаагүй бөгөөд эдгээрийг нэгтгэн шийдвэрлэж дүгнэлт өгөх нь зүйтэй гэж үзсэнийг дурдав.

Хоёр. С.Эрдэнийн Улсын Дээд шүүхийн цахим бүртгэлд бүртгэгдсэн Намын даргын бүртгэлийг сэргээх, Ц.Тувааныг намын даргын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийн талаар:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд зааснаар Улсын бүртгэлийн байгууллага нь хуулийн этгээдийн хувийн хэрэг хөтлөх бөгөөд мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.10.-т хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын овог, эцэг, /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний үнэмлэхний хуулбар хувийг хэргийн мэдээлэлд агуулагдахаар, тус мэдээлэлд өөрчлөлт орвол улсын бүртгэлд бүртгүүлэхээр тус тус зохицуулжээ.

Ардчилсан нам /АН/-ын Намын дүрмийн 5.17.1., 5.17.4.1.-д Намын дарга нь намын тэргүүн бөгөөд намыг төлөөлөх эрх бүхий этгээд болохыг тодорхойлсон байх тул нам нь улсын бүртгэлд бүртгэгдсэн мэдээлэлд өөрчлөлт орсныг бүртгүүлэх хүсэлт гаргах эрхтэй байна.

Урьд нь С.Эрдэнэ намын даргаар цахим бүртгэлд бүртгүүлэх, Ц.Туваан намын улсын бүртгэлийн гэрчилгээнд намын даргын үүрэг гүйцэтгэгчээр бүртгүүлэх хүсэлтийг тус тус гаргасныг Улсын Дээд шүүх 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр хэлэлцэж 04 дүгээр тогтоол гаргасан байна. Уг тогтоолоор "...Ардчилсан нам /АН/-ыг төлөөлөх эрхтэй этгээд, түүнийг улсын бүртгэлд бүртгүүлэх асуудал маргаантай гэж үзэж, хүсэлтүүдийг хангахаас татгалзаж, ...Намын дарга, түүнийг төлөөлөх этгээдийн талаар нам дотооддоо шийдвэрлэж, бүртгэл хийлгэхээр дахин хандах эрхтэй" гэж заажээ.

Иймд Улсын Дээд шүүхийн 04 дүгээр тогтоолд заасан үндэслэл арилсан эсэхийг шүүх хянах бөгөөд зөрчил арилсан гэж үзэх үндэслэл тогтоогдоогүй байна.

а/ С.Эрдэнийн намын даргын бүртгэлийг сэргээлгэхийг хүссэн хүсэлтэд:

Үндэсний бодлогын хороо /ҮБХ/-ны 2021 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн №05 тогтоол, Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-ны 2021 оны 01 дүгээр сарын 16-ны 04 тогтоолыг баримтаар хавсаргасан ба дээрх тогтоолоор "...Ц.Туваанд Ардчилсан нам /АН/-ын даргын эрх үүргийг шилжүүлсэн Үндэсний бодлогын хороо /ҮБХ/-ны 2020 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 16/06 тогтоол Үндсэн дүрэм, журам зөрчсөн нь тогтоогдсон тул хүчингүй болохыг тогтоож, Намын даргаар хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэсэн Улсын Дээд шүүхийн 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоол хүчинтэй байгаа тул 2020 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-ны тогтоолын дагуу Ардчилсан нам /АН/-ын дарга С.Эрдэнэ болохыг тогтоож, С.Эрдэнэ нь шинээр сонгогдсон Ардчилсан нам /АН/-ын даргад намын даргын эрх үүргээ шилжүүлэхийг дурдаж, намын шинэ дарга сонгогдтол С.Эрдэнэ бүрэн эрхтэй байхыг батламжилсан..." байна.

б/ Ц.Тувааныг Ардчилсан нам /АН/-ын даргын үүрэг гүйцэтгэгчээр улсын бүртгэлд бүртгүүлэхээр гаргасан хүсэлтэд:

Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-ны 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн №03 тогтоолыг хавсаргасан ба дээрх тогтоолоор "...Ардчилсан нам /АН/-ын даргын эрх үүргийг намын дараагийн дарга сонгогдох хүртэл Ц.Туваанд шилжүүлсэн Үндэсний бодлогын хороо /ҮБХ/-ны 2020 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 16/06 тогтоол нь Үндсэн дүрэм болон бусад журмыг зөрчөөгүй..." гэсэн дүгнэлт гарсан, Үндэсний бодлогын хороо /ҮБХ/-ны 16/06 тогтоолоор намын даргын эрх, үүргийг намын дараагийн дарга сонгогдох хүртэл Ц.Туваанд түр шилжүүлжээ.

в/ Ардчилсан нам /АН/-ын Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/ нь Үндсэн дүрэм, бусад журмыг сахиулах, хэрэгжилт болон намын үйл ажиллагаа, санхүү, гишүүний ёс зүй, сахилгын асуудалд хяналт тавих чиг үүрэг бүхий намын хяналтын төв байгууллага болох нь дүрмийн 15.21.1.-д тодорхойлогдсон бөгөөд хүсэлт гаргагч С.Эрдэнэ, Ц.Туваан нар аль аль нь

хүсэлтийн үндэслэл болгож, намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн талаар Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-ны хуралдаанаар хэлэлцэж тогтоосон гэж үзэн, тухайн тогтоолуудыг шүүхэд ирүүлсэн байна.

Иймээс шүүх Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-ны шийдвэр гаргасан үйл явц намын дүрэмд заасантай нийцсэн эсэхийг хянана.

Ардчилсан нам /АН/-ын Үндсэн дүрмийн 15.12.4.4., 15.21.4., 15.21.5. дахь заалтуудад Намын Их хурал Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-ны бүрэлдэхүүнийг намын даргын санал болгосноор батална, Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/ нь 15 гишүүний бүрэлдэхүүнтэй байна, Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-ны дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил байна гэж тус тус зохицуулжээ.

Тус шүүхэд хадгалагдаж буй Ардчилсан нам /АН/-ын бүртгэлийн баримтад 2017 онд хуралдсан тус Намын 7 дугаар Их хурлаар Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-ны гишүүдээр С.Мэндсайхан, Д.Бямбаа, Б.Болдбаатар, Л.Эрхэмбаяр, Т.Баяраа, Н.Мэдрээ, С.Ламбаа, М.Бөх-очир, Л.Байгаль, Н.Золжаргал, Д.Ганбаяр, Г.Баярсайхан, Б.Мягмардорж, Л.Доржсүрэн, Д.Энхбаяр нарыг санал болгосныг баталсан байна.

Намын 8, 9 дүгээр Их хурлаар Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-ны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцсэн боловч тухайн өөрчлөлттэй холбоотой баримт бүртгэлийн баримтад байхгүй байна.

Харин хүсэлт гаргагч талууд Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-нд 15 бус 14 гишүүн байгаа, намын 7 дугаар Их хурлаас баталсан гишүүнээс 4 гишүүн өөрчлөгдсөн гэсэн тайлбар гаргажээ.

С.Эрдэнэ, Ц.Туваан нарыг намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээд болохыг тогтоосон 2021 оны 01 дүгээр сарын 15, 16-ны өдрийн Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-ны хуралдаан тус бүр 14 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдахаар шийдвэр гаргасан байх боловч С.Эрдэнийг намын дарга болохыг батламжилсан Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-ны 2021.01.16-ны хуралдаанд Х.Ганболд, Д.Үүрийнтуяа, Д.Ганбаяр, А.Амгалан, Н.Ариунболд, Т.Баяраа, А.Долгормаа, Л.Доржсүрэн, Р.Хатанбаатар, С.Чинзориг, Ж.Төмөрбаатар, А.Зангад, Б.Мөнгөнсүх, Ч.Өнөрбаяр нар оролцохоос 7 гишүүн оролцсон, Ц.Тувааныг Намын дараагийн дарга сонгогдох хүртэл намын даргын эрх, үүргийг эдлэх эрхтэйг тогтоосон 2021.01.15-ны өдрийн Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-ны хуралдаанд Б.Мягмардаш, Д.Мэндбаяр, А.Амгалан, Н.Ариунболд, Т.Баяраа, Л.Доржсүрэн, А.Долгормаа, С.Ламбаа, Р.Хатанбаатар, А.Зангад, Ж.Төмөрбаатар, С.Чинзориг, Л.Эрхэмбаяр нар оролцохоос 10 гишүүн оролцож, тогтоолд тус тус гарын үсэг зурсан байна.

Дээрхээс үзвэл, намын Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/ 2 удаа хуралдаж эсрэг агуулгатай тогтоол гаргаснаас гадна хурал тус бүрт оролцсон гишүүдийн 4 нь өөр байх тул тэдгээрийн хэн нь эрх бүхий этгээд болох нь ойлгомжгүй болжээ.

Иймд намын даргын бүртгэлийн өөрчлөлтийн үндэслэл болсон Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-ны хуралдааны тогтоолыг хүчин төгөлдөр шийдвэр гэж үзэх үндэслэлгүй, улмаар Намын дарга, түүнийг төлөөлөх этгээдийн талаар нам дотооддоо шийдвэрлэх талаарх Улсын Дээд шүүхийн 04 дүгээр тогтоолд заасан зөрчил арилаагүй гэж үзлээ.

Дээр дурдсан үндэслэлээр С.Эрдэнийн Улсын Дээд шүүхийн цахим бүртгэлд бүртгэгдсэн намын даргын бүртгэлийг сэргээх, Ц.Тувааныг дараагийн намын дарга сонгогдох хүртэл намын даргын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг тус тус хангахаас татгалзах нь зүйтэй.

Гурав. Намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлтийн талаар:

Ардчилсан нам /АН/-ын Хэрэг эрхлэх газрын дарга П.Нүрзэд, Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-ны дарга Б.Мягмардаш нараас үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэхээр хүсэлт ирүүлжээ.

Өмнө нь намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлтийг Ц.Туваан гаргасныг Улсын Дээд шүүх 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр хэлэлцэж, 04 тогтоол гаргахдаа "...Намын 10 дугаар Их хурлыг хуралдуулсан болон тус хурлаар намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцсэн, санал хураасан үйл явц нь холбогдох хууль, дүрэмд бүрэн нийцээгүй байна. Тухайлбал, намын Их хурлыг эрх бүхий этгээд зарласан гэж үзэх боломжгүй ээлжит Их хурлыг 14 хоногийн өмнө зарлах журмын заалт зөрчигдсөн, дүрэмд заасан журмын дагуу Их хуралд томилогдох болон сонгогдон оролцох төлөөлөгчийн нэрс болоод ирц тодорхойгүй, төлөөлөгчдөд хурлын товыг хэрхэн мэдэгдсэн нь тогтоогдоогүй, хуралдаан дэгийн дагуу явагдсан эсэхэд дүгнэлт хийх боломжгүй, дүрмийн хэдэн хувьд өөрчлөлт оруулсан нь тодорхойгүй, улмаар дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсан зарим заалт дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай тогтоолоос зөрүүтэй байгаа талаар дурдсан байна.

Шүүхийн тогтоолд дурдсан дээрх зөрчил арилаагүй байна.

Хүсэлт гаргагчаас Намын Их хурлыг Намын дарга бус Үндэсний бодлогын хороо /ҮБХ/-ны 2020 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаас 2020 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулахаар товлон зарласан боловч Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахал дотоодод алдагдсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж, хатуу хөл хорио тогтоосноос тодорхойгүй хугацаагаар хойшилж, товлосон хугацаандаа хуралдаж чадаагүй, харин хөл хорио тавигдсаны дараа буюу 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдөр намын Улс төрийн зөвлөл хуралдаж, Намын Их хурлыг 2020 оны 12 дугаар сарын 18, 19-ний өдрүүдэд хуралдуулахаар шийдвэрлэж, намын даргын үүрэг гүйцэтгэгчид зөвлөмж хүргүүлснийг үндэслэн намын даргын үүрэг гүйцэтгэгч Ц.Туваан 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Намын Их хурлыг цахимаар хуралдуулахаар А/19 тушаал гаргасан нь дүрэм зөрчөөгүй гэжээ.

Эдгээр үйл баримтын талаар өмнөх хурлаар хэлэлцсэн бөгөөд Намын байгууллагуудын хурлын үйл ажиллагаа, зохион байгуулалтын дэгийн тухай журмын Дөрөв дүгээр зүйлийн 4.2.1-д намын Их хурлын хувьд Үндэсний бодлогын хороо /ҮБХ/ эсхүл намын даргын саналаар хуралдаан болохоос 14-өөс доошгүй хоногийн өмнө ээлжит хурлын тов, хэлэлцэх асуудлыг зарлана гэжээ.

Намын Х Их хурлыг ээлжит бус гэж тухайлан заагаагүй тул ээлжит Их хурал гэж үзэх бөгөөд журмын 4.2.1. дэх заалт хамаарахгүй гэх тайлбар үндэслэлгүй байна.

Анх Үндэсний бодлогын хороо /ҮБХ/ намын Их хурлын товыг дүрэмд заасан хугацаанд зарласан боловч товлосон өдрөө хуралдаагүй, харин хойшлогдсон хурлыг намын даргын үүрэг гүйцэтгэгч зарласан нь эрх бүхий этгээд гэж үзэхгүйгээс гадна журамд заасан хугацааг баримтлаагүй зөрчил арилаагүй байна.

Түүнчлэн Их хурлын төлөөлөгчдийн ирцийг тэдний ирүүлсэн анкетаар бүртгэсэн гэж тайлбарлах боловч анкетаа ирүүлсэн төлөөлөгчийг Их хуралд оролцсон төлөөлөгч гэж бүртгэх боломжгүй, хурлын бичлэг, тэмдэглэлээс Их хурлын төлөөлөгчийн ирцийг бүртгэсэн үйл баримт тогтоогдоогүй тул хурлын ирцтэй холбогдуулан тухайн Их хурлыг хүчинтэй гэж үзэх үндэслэл тогтоогдсонгүй.

Нэгэнт Намын Х Их хурал хүчингүй тул тус хурлаар хэлэлцэж, баталсан бусад асуудлыг хүчин төгөлдөр гэж үзэх боломжгүй.

Улс төрийн намын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.-т "намын дүрэм, мөрийн хөтөлбөр, тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль, энэ хуультай эсэхэд Улсын Дээд шүүх хяналт тавина..." гэж зохицуулсан.

Улсын Дээд шүүх ийнхүү хяналт тавихдаа тухайн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж, хэлэлцэн баталсан үйл ажиллагаа Намын дүрэм холбогдох журмын дагуу явагдсан эсэх, өөрчлөлт оруулсан дүрмийн зохицуулалт Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцсэн эсэхийг тогтооно.

Дээр дурдсан үндэслэлээр тус намын дүрмийн өөрчлөлтийг бүртгэхээс татгалзсан Улсын Дээд шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 04 дүгээр тогтоолд заасан зөрчил арилаагүй гэж үзэх тул Ардчилсан нам /АН/-ын Х Их хурлаар хэлэлцэж, баталсан Намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгэхээс татгалзах нь зүйтэй.

Дөрөв. Ардчилсан нам /АН/ нь намын даргын маргаантай асуудал болон намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаа дүрэмд заасан журмын дагуу дахин шийдвэрлэж, тогтоолд заасан зөрчлийг арилгасны эцэст бүртгэл хийлгэхээр шүүхэд дахин хандах эрхтэй болохыг дурдах нь зүйтэй.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4., Улс төрийн намын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.-т заасныг удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1. С.Эрдэнийн Улсын Дээд шүүхийн цахим бүртгэлд Ардчилсан нам /АН/-ын даргаар бүртгэгдсэн бүртгэлийг сэргээлгэх хүсэлтийг хангахаас татгалзсугай.

2. Ц.Тувааныг Ардчилсан нам /АН/-ын дараагийн даргыг сонгогдох хүртэл намын даргаар бүртгүүлэх хүсэлтийг хангахаас татгалзсугай.

3. Ардчилсан нам /АН/-ын Намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгэхээс татгалзсугай.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ

Г.АЛТАНЧИМЭГ

ШҮҮГЧИД

Д.ЦОЛМОН

Х.ЭРДЭНЭСУВД